



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/721

Булган сум

**Байнгын асаргаатай хөгжлийн бэрхшээлтэй
хүүхэдтэй өрхөд эргэлт хийх зардалд
хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.2 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг шинэчлэн батлах тухай” А/648 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах сарын аяны хүрээнд Булган сумын байнгын асаргаатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд гэрийн эргэлт хийх ажлыг зохион байгуулсугай.

2.Гэрийн эргэлт хийхэд шаардагдах 6,501,000 (зургаан сая таван зуун нэг мянга) төгрөгийг хавсралтаар баталж Аймгийн Засаг даргын 2025 оны хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээ хэрэгжүүлэх зардлын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

3.Тус үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг), Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга (Н.Батжаргал) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6325011005

Аймгийн Засаг даргын 2025 оны
дүгээр сарын 20-ны өдрийн
... дугаар захирамжийн хавсралт

БУЛГАН СУМЫН БАЙНГЫН АСАРГААТАЙ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ
ХҮҮХЭДТЭЙ ӨРХӨД ЭРГЭЛТ ХИЙХЭД ШААРДАГДАХ ТӨСӨВ

д/д	Зардлын төрөл	Тоо, ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5
1	Эрүүл мэндийн багц (витамин, вакус, түрхлэг)	55	80,000	4,400,000
2	Живх (дэвсдэг, өмсдөг)	55	30,000	1,650,000
3	Чихэр	55	8,200	451,000
Дүн				6,501,000